



СУХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 54

Баруун-Урт

Г ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН ДҮНГЭЭР АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.7, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 70 дугаар зүйлийн 70.4, 77 дугаар зүйлийн 77.2.2, “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 12.1.2 дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого”-ын дүнг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг дарга /3.Энхтөр/-д даалгах нь:

1. Орон нутгийн чанартай автозам, гүүр, авто зогсоол, явган замыг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгуулах, арчилгаа цэвэрлэгээг мэргэжлийн байгууллагаар байнга хийлгэх, жил бүр зам, гүүр, авто зогсоолын засвар үйлчилгээний зардлыг төсөвт суулган мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээг хийлгэх.
2. Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүй орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, эрхлэгч нарт арга хэмжээ авах.

Хоёр. Сумдын Засаг дарга, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, эрхлэгч нарт даалгах нь

1. Элэгдлээрээ ёртөгөө нөхсөн, техник, технологийн хоцрогдолд орж ашиглагдахгүй байгаа хөрөнгүүдийг актлаж данснаас хасах шийдвэрийг гаргуулах.

2. Маргаантай болон дутагдсан хөрөнгийн хувьд хууль, хяналтын байгууллагуудад хандаж асуудлыг шийдвэрлэх, төлбөрийг барагдуулах талаар яаралтай арга хэмжээ авч тайлагнах.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор данс бүртгэлд тусгаагүй улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын хандив, тусламж, бэлэглээр бий болсон хөрөнгүүдийг хуримтлагдсан элэгдлийг нөхөн тооцож данс бүртгэлд тусгах.
4. Бараа материал дээр үндсэн хөрөнгийн шинж чанартай, үндсэн хөрөнгө дээр бараа материалын шинж чанартай, үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэгдсэн хөрөнгүүдийг 2016 онд багтаан данс бүртгэлд зөв болгон бүртгэх.
5. Өөрийн байгууллагын балансад бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн эзэмшил газар болон байгууллагын эзэмшлийн газраа аваагүй, эзэмшил газраа эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулаагүй орон нутгийн өмчит хуулийн этгээд 2017 оны 1-р улиралд багтаан дээрх, арга хэмжээг холбогдох газруудтай хамттан хэрэгжүүлэх.
6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл, худаг, услалтын систем, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хувийн хэргийг 2017 оны 1-р улиралд батгаан мэргэжлийн байгууллагуудтай хамтран нээж, хөтлөн хэрэгжүүлэх.
7. Худаг, уст цэг, услалтын системийг нэг бүрчлэн тоолж, дарагдсан, ашиглагдахгүй хөрөнгийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран гаргаж 2017 оны 2-р улиралд батгаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх.



ДАРГА

Б.ГАНСҮХ